

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Ланд крузер 70 серийн автомашины хөдөлгүүрт ээлж хийх сэлбэг” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/201907480 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 1

0 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 75055555-511**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|--|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ</i> -д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Үнийн саналыг жишиг маягтын дагуу ирүүлэх:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Сүүлийн 1 жилийн буюу 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлэх; 3. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлж байсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээлэгч байгууллагын тодорхойлолт ирүүлэх; 4. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/ 5. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/ 6. Тендерт санал болгосон үнээр, санал болгосон хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлэх 7. Заасан маркын автомашины сэлбэг, эд ангийг нийлүүлэх зөвшөөрөлтэй буюу үйлдвэрлэгч, дистрибьютер, албан ёсны гэрээт борлуулагчийн аль нэгээр ажилладаг болохыг нотлох баримт бичиг, гэрчилгээ, гэрээний хуулбар зэргийг баталгаат орчуулгаар орчуулга хийлгэж ирүүлэх; 8. Нийлүүлэхээр санал болгож буй барааны үйлдвэрийн баталгаа бүхий ШИНЭ сэлбэг, хэрэгслийн нэр загвар, техникийн тодорхойлолт, үзүүлэлтийн жагсаалт, сэлбэг эд ангийн дугаар (part number) 9. Нийлүүлэхээр санал болгож буй сэлбэг, эд анги нь тухайн техникт таарахгүй тохиолдолд Захиалагчийн хүсэлтээр үнийн саналд өөрчлөлт оруулахгүйгээр таарах сэлбэгээр сольж нийлүүлэхийг баталсан тухай албан бичиг ирүүлэх;
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын www.tender.gov.mn/ цахим системд ирүүлэх</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 10 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхарт нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Landcruiser-70 серийн автомашины
хөдөлгүүрийн ээлж хийх сэлбэгийн
техникийн тодорхойлолт**

Landcruiser-70 серийн автомашины хөдөлгүүрт ээлж хийхэд шаардлагатай сэлбэг, эд ангийг нийлүүлэгч нь доорх (хүснэгт-1)-т заагдсан үндсэн үзүүлэлт, хөдөлгүүр, сериал дугаарын дагуу шалгаж баталгаажуулсан байх ба тухайн үйлдвэрлэгчийн оригиналь сэлбэгийг борлуулах албан ёсны эрх бүхий байгууллага байх шаардлагатай.

Автомашины үндсэн үзүүлэлт

Хүснэгт 1

№	Загвар	Зориулалт	Сериал дугаар	Үйлд.улс	Үйлд он
1	Landcruiser-76	Суудал	JTERB71J907021318	Япон	2013
2	Landcruiser-78	Суудал	JTERB71J200091205	Япон	2017
3	Landcruiser-7070	Суудал	JTEBB71J204001190	Япон	2013
4	Landcruiser-76	Суудал	JTEEB71J507013765	Япон	2012
5	Landcruiser-78	Суудал	JTERB71J300071738	Япон	2013
6	Landcruiser-78	Суудал	JTERB71J000065671	Япон	2012
7	Landcruiser-76	Суудал	JTEEB71JX07012001	Япон	2011
8	Landcruiser-76	Суудал	JTGEB73J9B9006684	Япон	2011
9	Landcruiser-76	Суудал	JTEEB71J807040832	Япон	2017
10	Landcruiser-76	Суудал	JTEEB71J307024313	Япон	2014
11	Landcruiser-76	Суудал	JTEEB71J907021819	Япон	2013
12	Landcruiser-78	Суудал	JTERB71J800071489	Япон	2013
13	Landcruiser-78	Суудал	JTERB71J000075732	Япон	2014
14	Landcruiser79	Pick up	JTERB71J2C8030850	Япон	2011
15	Landcruiser79	Pick up	JTERB71JXC8030529	Япон	2011
16	Landcruiser-78	Суудал	JTERB71J100061538	Япон	2011
17	Landcruiser-76	Суудал	JTEEB71J907012666	Япон	2011
18	Landcruiser79	Pick up	JTEBB71J404331560	Япон	2017
19	Landcruiser-78	Суудал	JTERB71J300090189	Япон	2017
20	Landcruiser-76	Суудал	JTEEB71J207024156	Япон	2014
21	Landcruiser-7070	Суудал	JTEBB71J304001196	Япон	2013
22	Landcruiser-76	Суудал	JTERB71J600094656	Япон	2018
23	Landcruiser-76	Суудал	JTERB71J500094681	Япон	2018
24	Landcruiser-78	Суудал	JTEEB71JX07044204	Япон	2018
25	Landcruiser-76	Суудал	JTEEB71J407044912	Япон	2018
26	Landcruiser-70	Суудал	JTEBB71J604338297	Япон	2018
27	Landcruiser-78	Суудал	JTEBB71J604338297	Япон	2018
28	Landcruiser-76	Суудал	JTEEB71J007044907	Япон	2018

Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, шинэ сэлбэг байна.
- ✓ Нийлүүлэгч нь Хүснэгт 2-т заагдсан сэлбэг, эд ангийн жагсаалтын дагуу үнийн санал ирүүлнэ.
- ✓ Уг захиалга нь захиалагчийн гаргасан захиалгын, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч нь LC-70 серийн автомашины оригиналь сэлбэг, эд анги нийлүүлэх албан ёсны эрх бүхий байгууллага байна.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.
- ✓ Нийлүүлсэн сэлбэг нь чанарын шаардлага хангасан оригиналь үйлдвэрийн сэлбэг байна.

#

				Хүснэгт 2	
№	Бараа, ажил, үйлчилгээ	Сэлбэгийн дугаар	Хэмжих нэгж	Тоо,ш	
Хөдөлгүүр					
1	Хөдөлгүүрийн жийрэг	Хүснэгт 1	Ком	6	
2	Нударган гол		ш	6	
3	Нударган голны вкладыш		ш	6	
4	Тосон клапан		ш	72	
5	Крышканы жийрэг		ш	6	
6	Тосон клапангийн толь		ш	72	
7	Хөдөлгүүрийн тосны насос		ш	6	
8	Хуруувч резин		ш	72	
9	Гаргах босоо клапан		ш	36	
10	Оруулах клапан		ш	36	
11	Зүлгүүр		ш	6	
12	Силекон		ш	6	
13	Түлшний аппаратур		ш	2	

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Landcruiser-70 серийн автомашины хөдөлгүүрийн ээлж хийх сэлбэг	Хөдөлгүүрийн жийрэг	6	ком	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ны төв агуулах дээр бууна.	Гэрээ байгуулагдаж, захиалга өгсөнөөс хойш 10 хоногоос 1 жил /нэг жил хүчинтэй байна/	Захиалагч захиалага өгсөнөөс хойш 10 хоногоос 1 жил /нэг жил хүчинтэй байна/	
	Нударган гол	6	ш				
	Нударган голны вкладыш	6					
	Тосон клапан	72					
	Крышканы жийрэг	6					
	Тосон клапангийн толь	72					
	Хөдөлгүүрийн тосны насос	6					
	Хуруувч резин	72					
	Гаргах босоо клапан	36					
	Оруулах клапан	36					
	Зүлгүүр	6					
	Силекон	6					
	Түлшний аппаратур	2					

Тав. **ЖИШИГ МАЯГТ**
1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] ажлын хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1.1 Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан барааг технологийн дагуу нааж гүйцэтгэсэний дараа Захиалагч шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Нийлүүлэгч тал хариуцна.
- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1.1 нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Төлбөр (ГЕН-7)**
- Төлбөр: Бараа хүлээлцсэн акт, нийлүүлэгч талын нэхэмжлэлийг үндэслэн захиалагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг төлнө.
- Төлбөрийг ажлын гүйцэтгэлээр буюу тухайн гаргасан захиалгын дагуу нэхэмжлэл, барааг нааж гүйцэтгэсэн болон хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн барааг нааж гүйцэтгэсэнээс хойш ажлын 10 хоногт төлнө.
- 4. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 1.1 Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хоногт 0.5 хувийн алданги тооцно.
- Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь байна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.